



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/104

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зэвсэгт хүчний 341 дүгээр ангид байлдааны туг гардуулах, хугацаат цэргийн алба хаагчийн байрын нээлтийн үйл ажиллагааны арга хэмжээ, ангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн нэмэлт дансанд шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

